



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Сургалтанд оролцуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Журам батлах тухай” 119 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 2016 оны сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай” А/11-р тушаал, ЭМС-ын сайдын 2016 оны “Төгсөлтийн дараах гадаад сургалтын тэргүүлэх чиглэл батлах тухай” А/169-р тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНСУ-ын Пундаан Ча төв эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах суралцагчдын нэрс, мэргэжлийн чиглэл, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Эмч эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтанд шаардагдах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын явцын тайланг сургалт эхэлснээс 7 хоногт багтаан бичгээр, суралцаж ирээд төгсөлтийн тайланг 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дахь сард Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн албаны дарга /З.Наранбаатар/-д, байгууллагын удирдлагад амаар болон бичгээр ирүүлэхийг багийн ахлагчид тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг /Ч.Баттулга/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



420464